

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Ажил олгогч болон даатгуулагч 5 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлнө”, мөн зүйлийн 2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй”, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авсны дүнд ажил олгогч 3 жил дараалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлж болно”, мөн зүйлийн 2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй” гэж тус тус заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2011 оны 16 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан. Дээрх хуулиудийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.7-д “Ажил олгогчид хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж тус тус заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол болон журмын төсөл боловсруулав.

Одоогийн мөрдөж байгаа хуулиар ажил олгогч болон даатгуулагч 5 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлнө, заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй гэж, ажил олгогч үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авсны дүнд 3 жил дараалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлж

болно, заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй гэж тус тус заасан.

Харин шинээр батлах журамд даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулан 3 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй, Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ, шимтгэлийн хөнгөлөлтийг дараа жилийн төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэлээс хасаж тооцно гэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн нөхцөлийг 3 жил дараалан хангасан ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн шимтгэлийн 15 хүртэлх хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа үзүүлнэ гэж заасан байна. Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтныг тохирсон ажлын байраар хангагдсан ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцон ажил олгогчоос хариуцан төлөх шимтгэлийг 12 хүртэлх сарын хугацаанд чөлөөлнө. Ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт хэмжээ нь ажил олгогчийн тухайн жилд төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй гэж тус тус заасан.

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 52.6 тэрбум төгрөг, зарлага 80.3 тэрбум төгрөг /30516 иргэнд/ байсан. 2023 онд 81.4 тэрбум төгрөг төсөвлөснөөс 2023 оны 7 дугаар сарын байдлаар 17782 иргэнд 60,6 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2024 онд орлого 125.9 тэрбум төгрөг, зарлага 125.5 тэрбум төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2019 онд 18.0 мянган ажил олгогчид 3.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна. 2024 онд 19.6 мянган ажил олгогчид 5.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлэх тооцоололтой байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 2022 оны орлого 202.2 тэрбум, зарлага 40.6 тэрбум төгрөг байна. 2023 онд орлого 231.4 тэрбум төгрөг, зарлага 43.9 тэрбум төгрөг, 2024 онд орлого 242.9 тэрбум төгрөг, зарлага 59.3 тэрбум төгрөг тус тус төсөвлөсөн байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ